



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 97.

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.3 дахь хэсэг, "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн тухай" Засгийн газрын 1997 оны 52, 53 дугаар тогтоол, "Тогтоолын хавсралт шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2012 оны 142 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний салбарын "Эрчим хүчний тэргүүний ажилтан" болон яамны "Жуух бичиг"-ээр шагнах журмыг нэгдүгээр хавсралтаар, "Шагналд нэр дэвшигчийн анкетын загвар"-ыг хоёрдугаар хавсралтаар, "Эрчим хүчний тэргүүний ажилтан"-ны гэрчилгээ, тэмдэгний загварыг гуравдугаар хавсралтаар, яамны "Жуух бичиг"-ийн дотор, гаднах хавтасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. "Эрчим хүчний тэргүүний ажилтан" шагналын гэрчилгээ, тэмдэг хийлгэх зардал болон яамны "Жуух бичиг"-ийн дотор, гаднах хавтас хийлгэх зардлыг яамны төсвөөс гаргаж байхыг Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтэс /Б.Баясгалан/-т даалгасугай.

3. Энэхүү журмыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /М.Баярмагнай/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Түлш, эрчим хүчний сайдын 2004 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 24 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

 П.ГАНХҮҮ

Эрчим хүчний сайдын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 27 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 142 дугаар тогтоолын дагуу Эрчим хүчний сайдын шийдвэрээр олгох "Эрчим хүчний тэргүүний ажилтан", яамны "Жуух бичиг"-ээр тус салбарыг хөгжүүлэхэд идэвхи зүтгэл, үр бүтээл, ажлын онцгой амжилт гаргасан, салбарын бүтээн байгуулалтад тодорхой хувь нэмэр оруулсан хүмүүсийг эрчим хүчний салбарын шагналаар шагнахад энэхүү журмыг мөрдөнө.

2. Эрчим хүчний салбарын шагналын зорилго нь салбарын ажилтнуудын хөдөлмөр, зүтгэл, амжилт, бүтээлийг үнэлэх, тэдний идэвхи санаачлагыг дэмжиж урамшуулахад оршино.

3. Эрчим хүчний салбарын шагналыг олгохдоо шагналд нэр дэвшсэн ажилтны ажлын амжилт, бүтээл, тус салбарт ажилласан хугацааг гол шалгуур болгохын зэрэгцээ тухайн ажилладаг байгууллагын үйл ажиллагаа, бүтээн байгуулалт, ажлын үр дүнг харгалзан үзэж олгоно.

Хоёр. Шагналын төрөл

2. Эрчим хүчний салбарын шагнал нь дараахь хоёр төрөлтэй байна. Үүнд:

2.1. Засгийн газрын шагнал:

2.1.1. "Эрчим хүчний тэргүүний ажилтан" үнэмлэх, хүндэт тэмдэг;

2.2. Эрчим хүчний яамны шагнал:

2.1.2. Яамны "Жуух бичиг".

Гурав. Шагнал олгох ерөнхий нөхцөл

3.1. Эрчим хүчний салбарыг хөгжүүлэхэд идэвхи, зүтгэл гарган мэргэжлээрээ 15-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж, амжилт бүтээл нь хамт

олон, мэргэжлийн хүмүүст үнэлэгдсэн, мэргэжлийн туршлагатай, өндөр чадвартай ажилтныг “Эрчим хүчний тэргүүний ажилтан” үнэмлэх, хүндэт тэмдэг болон яамны “Жуух бичиг”-ээр шагнах бөгөөд өмнө нь Эрчим хүчний яамны “Жуух бичиг”-ээр шагнагдсан байна.

3.2. Тус салбарт 10-аас доошгүй жил идэвхи санаачилгатай ажиллаж, ажил үйлсээрээ бусдыгаа тэргүүлсэн ажилтнуудыг Эрчим хүчний яамны “Жуух бичиг”-ээр шагнана.

3.3. Салбарын шагналаар шагнуулах хүмүүсийг дор дурдсан шалгуур үзүүлэлтийг үндэслэн шагнана. Үүнд:

3.3.1. Салбарын тэргүүний ажилтнаар шагнуулах санаачилгыг өмчийн аливаа хэлбэрийг харгалзахгүйгээр тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага гаргаж болно. Шагналд нэр дэвшиж байгаа хүн нь эрчим хүчний салбарт 15-аас дээш жил ажилласан, тухайн хамт олны дотор 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажилласан болон ажиллаж буй ажилтан, ажилчид;

3.3.2. Эрчим хүчний салбарын үйлдвэр, компанийн үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлж, үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг ханган, өндөр үр ашигтай ажиллуулах, дэвшилтэт шинэ техник, технологи эзэмшин нэвтрүүлэх, үйлчилгээний нэр төрөл, хүрээг өргөтгөх, шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэл, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд санаачилга гаргасан, экспортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, импортын сэлбэг дотооддоо үйлдвэрлэх зэрэгт мэргэжлийн ур чадвараа дайчлан ажилласан удирдах болон инженер техникийн ажилтан, ажилчид;

3.3.3. Ажлын амжилтаараа хамт олноо манлайлан ажиллаж, мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажил, үйлчилгээг үйлчлүүлэгчдийн эрх ашигт нийцүүлж чанартай гүйцэтгэн эрхэлсэн ажилдаа өндөр амжилт гарган идэвхи санаачилгатай, техникийн осол, зөрчилгүй ажиллаж байгаа ажилтан, ажилчид;

3.3.4. Салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, сургахад бодитой хувь нэмэр оруулсан, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд амжилт, нээлт, бүтээл гаргасан багш, эрдэмтэд;

3.3.5. Салбарыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан төр, олон нийтийн байгууллагын зүтгэлтэн, ахмадууд, гадаадын иргэн;

3.3.6. Салбарын ажил, үйлчилгээнд онцгой үр дүн өгөхүйц нээлт, шинэ бүтээл, санаачилга, үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангах эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой шинэ техник, технологи, шилдэг арга, ажиллагаа нэвтрүүлсэн ажилтан, иргэд;

3.3.7. Үйлдвэрлэлд учирч болохуйц ноцтой аюул, аваарь, ослыг урьдчилан сэргийлж, таслан зогсоох арга хэмжээ авсан, түүний хохирол уршгийг арилгах, түүнчлэн нэн төвөгтэй үүрэг, даалгаврыг иргэний зориг гарган гүйцэтгэсэн ажилтан, ажилчид;

3.3.8. Улс орны болон салбарын хэмжээний тулгамдсан зорилтыг шийдвэрлэхэд онцгой ач холбогдолтой хууль, төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх ажилд тодорхой үүрэг гүйцэтгэсэн ажилтан, албан хаагчид;

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

4.1. Салбарын тэргүүний ажилтнаар шагнуулах санаачилгыг өмчийн аливаа хэлбэрийг харгалзахгүйгээр тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага гаргаж болох бөгөөд ямар нэг байгууллагад харьяалагддаггүй иргэнийг харьяалах нутаг дэвсгэрийн төрийн захиргааны байгууллага тодорхойлох ба холбогдох яамны саналыг харгалзан үзнэ.

4.2. Сонгуульт болон нам, олон нийтийн байгууллага нь гишүүд, идэвхтнээ шагнуулах саналыг тухайн ажиллаж байсан үндсэн байгууллагад нь гаргана.

4.3. Шагналд нэр дэвшигч нь энэхүү журмын 3.3.-т заасан болзлыг бүрэн хангасан байна.

4.4. “Эрчим хүчний тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагнуулахаар нэр дэвшигч нь яамны “Жуух бичиг”-ээр шагнагдсан байх ба шагнуулснаас хойш 5-аас доошгүй жил тогтвортой ажиллаж, ажлын амжилт бүтээл нь өмнөх түвшингээс ахисан нөхцөлд дараагийн шатны шагналд нэр дэвшүүлнэ.

4.5. “Шагнал олгох журам”-ын 3.3.6, 3.3.7, 3.3.8 дахь хэсэгт заасан үзүүлэлтээр шагнагдах хүмүүст ажилласан жил, шагнал хоорондын хугацааг хамааруулахгүй байж болно.

4.6. Шагнуулах иргэдийн материалыг нийтээр тэмдэглэх баяр /Цагаан сар, Үндэсний их баяр наадам, Улс тунхагласны баяр/ болон салбарын ажилтны өдөр, салбарын байгууллагуудын 20-оос дээш жилийн, 10 жилийн давтамжтайгаар тэгш ойг тохиолдуулан шагнах бөгөөд “Шагнал олгох журам”-ын 4.8-д заасан үзүүлэлтийг үндэслэн шагнах тохиолдолд энэ хугацаа хамаарахгүй байж болно.

4.7. Шагналын холбогдох материалыг 30-аас доошгүй хоногийн өмнө зөвхөн цаасан хэлбэрээр Эрчим хүчний яаманд ирүүлэх ба хугацаа хожимдуулсан тохиолдолд дараагийн тэмдэглэлт баяр, ойгоор асуудлыг шийдвэрлэнэ.

4.8. Эрчим хүчний салбарын шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлж буй ажилтны ажил байдлын тодорхойлолтод түүний шагнуулах үндэслэлийг тодорхой

ичиж, ажлын үзүүлэлт, судалгаа, тооцоогоор баталгаажуулан, бүтээлийн жагсаалтыг хавсаргаж дараах материалын хамтаар ирүүлнэ. Үүнд:

4.8.1. Шагналд өргөн мэдүүлсэн хүний анкет /Журмын хоёрдугаар хавсралт/;

4.8.2. Ажил байдлын тодорхойлолт, бүтээлийн жагсаалт;

4.8.3. Иргэний үнэмлэхний хуулбар;

4.8.4. Байгууллагын нийт хамт олны хурлын тэмдэглэл;

4.8.5. Урьд өмнө нь шагнагдсан бол шагналын хуулбар;

4.8.6. Шагнуулах тухай эрх бүхий албан тушаалтны гарын үсэгтэй албан бичиг;

4.8.7. Онцгой амжилт гаргасан /энэ журмын 3.3.6, 3.3.7, 3.3.8/ бол түүнийг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар.

4.9. Салбарын шагналаар шагнуулахаар ирүүлсэн материалыг яамны бичиг, эргийн ажилтанд хүлээлгэн өгч бүртгүүлэх ба түүнийг холбогдох шагнал тариуцсан ажилтан хянан үзэж, удирдлагад танилцуулан саналыг авч, “Шагнах тухай” Эрчим хүчний сайдын тушаалыг боловруулан албажуулж, шийдвэрлүүлнэ.

4.10. Энэхүү журмын 4.8.-д заасан материалыг дутуу ирүүлсэн тохиолдолд үндэслэлийг дурдан тодорхойлолт ирүүлсэн байгууллагад буцаана.

Тав. Шагналыг шийдвэрлэх, олгох

5.1. Эрчим хүчний яамны Төрийн захиргааны удирдлагын газар шагналын материалыг хүлээн авч, энэ журмын дагуу ирүүлсэн материалыг судалж, хянан үзсэний үндсэн дээр удирдлагад танилцуулан саналыг авч шийдвэрлэнэ.

5.2. Шагнах асуудлыг Эрчим хүчний сайдын тушаалаар шийдвэрлэнэ.

5.3. “Эрчим хүчний тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагнахад Засгийн газрын 2012 оны 142 дугаар тогтоолыг үндэслэн 100000 /нэг зуун мянга/ төгрөг, яамны “Жуух бичиг”-ээр шагнахад Засгийн газрын 1997 оны 53 дугаар тогтоолыг үндэслэн 10000 /арван мянга/ төгрөгийн дагалдах мөнгөн шагналыг тухайн ажилтныг шагнуулахаар тодорхойлсон үндсэн байгууллагаас нэг удаа олгоно.

5.4. “Эрчим хүчний тэргүүний ажилтан”, яамны “Жуух бичиг”-ээ гээж, үзэгдүүлсэн тохиолдолд үнийг нь төлүүлж, нөхөж олгож болно. Нөхөн авахад дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

5.4.1. Шагнал нөхөн олгохыг хүссэн өргөдөл /гараар бичсэн байх/;

5.4.2. Өмнө нь шагнагдсан шагналын хуулбар.

5.4.2. Иргэний үнэмлэхний хуулбар.

Зургаа. Бусад

6.1. Салбарын шагналаар шагнагдагсдад хувийн дугаар бүхий гэрчилгээ олгох ба тэмдэг үнэмлэхний загварыг Эрчим хүчний сайдын тушаалаар батална.

6.2. Салбарын шагналаар шагнагдсан хүний бүртгэлийг хөтлөх, шагналыг олгох ажлыг яам хариуцна.

6.3. Шагнуулахаар ирүүлсэн материалыг архивын ажлын үндсэн зааврын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлэн архивлана.



Эрчим хүчний сайдын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 97 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ШАГНАЛД ШАГНУУЛАХААР ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХҮНИЙ АНКЕТ

1. Ургийн овог:
2. Эцэг /эх/-ийн нэр:
3. Өөрийн нэр:
4. Төрсөн он, сар, өдөр:
5. Регистрийн дугаар:
6. Нас:
7. Хүйс:
8. Яс үндэс:
9. Ажил эрхлэлтийн байдал

3x4,
4x6
Цээж зураг

Д/д	Байгууллагын нэр	Ажилласан хугацаа	Албан тушаал

10. Нийт ажилласан жил:, үүнээс тухайн салбарт: жил, тухайн хамт олны дотор жил.

11. Урьд нь шагнагдаж байсан шагналууд /шагналын хуулбарыг заавал хавсаргах/

Д/д	Шагналын нэр	Шагнагдсан он

12. Шагнуулах үндэслэл /Сүүлийн 5 жилээр тодорхой бичих/

13. Засгийн газрын ямар шагналд нэр дэвшүүлж буй санал:

.....

14. Хамт олны санал:

15. Байгууллагын холбоо барих утас, хаяг:

.....
.....
.....

Баталгаажуулсан:

Захирал /дарга, эрхлэгч/...../Нэр/

(Гарын үсэг)
(Тамга, тэмдэг)

Он, сар, өдөр

Эрчим хүчний сайдын 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 97 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН

1. Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдэг нь гонзгой дугуй хэлбэртэй, тухайн салбар, ажил мэргэжлийн чиглэл, онцлогийг бэлэгдсэн дүрслэлтэй, салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн оноосон нэрийг монгол үсгээр бичсэн байна. Тэмдгийн дээд хэсэгт соёмбо дүрсэлсэн байна.
2. Тэмдгийн урт нь 45 мм, өргөн нь 30 мм, зузаан нь 8 мм байна.
3. Тэргүүний үнэмлэхний урт нь 210 мм, өргөн нь 150 мм байна.
3. Тэмдэг болон үнэмлэхний тухайлсан загварыг Эрчим хүчний сайд батална.
4. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгээр шагнагдагсдад хувийн дугаар бүхий үнэмлэх олгоно.
5. Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгээр шагнахад 100000 /нэг зуун мянга/ төгрөгийн мөнгөн шагналыг нэг удаа олгоно.

